



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТНОРОВ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2021 оны 06 сарын 03 өдөр

Дугаар А/79

Батноров сум

**Газар эзэмшүүлэх эрх
шилжүүлэх тухай**


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, 59 дүгээр зүйлийн 59.1.16 дахь заалт, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай нотлох баримтыг бүрдүүлэн хүсэлт гаргасны дагуу иргэн Туваанжав овогтой Оюунтуяагийн Дундбүрд 6 дугаар багийн Бүрд гудамжны 901 а тоотод байрлах гэр бүлийн хэрэгцээний зориулалттай 2304012116 нэгж талбарын дугаар бүхий 379 квадрат метр газрын эзэмших эрхийг иргэн Чинхүү овогтой Хатанбаатарт шилжүүлсүгэй.

2. Газар эзэмших гэрээг жил бүр дүгнүүлж, газрын төлбөрийг хугацаанд нь төлж, Газрын тухай хууль болон гэрээнд заагдсан заалтуудын дагуу эзэмшихийг Ч.Хатанбаатарт үүрэг болгосугай.

3. Газар эзэмших эрхийн гэрчилгээг олгон гэрээ байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг газрын даамал (Э.Зулцэцэг)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2022 оны А/56 тоот захирамжийг хүчингүй болгосугай.



Б.ЖАВХЛАНБАЯР

2304012116